



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2024 оны 03 сарын 20 өдөр

Дугаар Б/20

Эг

┌ Ө.Сарантуулд урамшуулал олгох тухай ┐


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 03 дугаар хавсралтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Архив, бичиг хэргийн ажилтан Өлзийсайханы Сарантуулд цахим мэдээ мэдээлэл хариуцан ажиллаж байгаатай холбогдуулан 2023 оны ажлын үр дүнгээ хангалттай сайн үнэлүүлсэн тул 2024 оны 1 дүгээр улирлын урамшууллыг үндсэн цалингийн 40%-иар тооцон олгосугай.

2. Цаашид улирал бүр ажлын үр дүнгээ дүгнүүлэн ажиллахыг (Ө.Сарантуул)-д даалгасугай.

3. Урамшууллыг 2024 оны цалингийн сангаас тооцон олгохыг нягтлан бодогч (Б.Минжинсор)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Б.ӨРДЭНЭЧИМЭГ

202405039